УЛААНБААТАР ХОТЫН ЕРӨНХИЙ МЕНЕЖЕРИЙН ТУШААЛ

2019 оны 10 сарын 18 өдөр Дугаар А/329 Улаанбаатар хот

Хөрөнгө гаргах тухай

Төсвийн тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.5.5, Нийслэлийн засаг даргын зөвлөлийн 2019 оны 01 дүгээр хуралдааны тэмдэглэл, Улаанбаатар хотын Захирагчийн ажлын албаны дүрмийн 2 дугаар хэсгийн 2.2, 3 дугаар зүйлийн 3.1.3, 4 дүгээр хэсгийн 4.4.2, Улаанбаатар хотын ерөнхий менежерийн зөвлөлийн 2019 оны 15 дугаар хурлын тэмдэглэлийг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1. Улаанбаатар хотын ногоон байгууламжийн намрын тарилт, арчилгаа, хамгааЛалтын хүрээнд хийгдэх зарим ажлын болон зорилтот аяны хүрээнд хийгдэх ажлын жагсаалтыг хавсралт ёсоор баталсугай.

2. Тушаалын хавсралтын 1-7-р жагсаалтад тусгагдсан ажлуудыг гэрээний үндсэн дээр гүйцэтгүүлэх ажлыг зохион байгуулж, ажлын явц, үр дүнд хяналт тавьж ажиллах, “Манай хороо – Миний гудамж” аяны шалгаруулалтад шилдэг хороогоор шалгарсан 5 дүүргийн 6 хороог шагнаж, урамшуулах ажлыг зохион байгуулахыг Хотын тохижилт, цэцэрлэгжүүлэлтийн хэлтэс /М.Гансэлэм/-т даалгасугай.

3. Дээрх ажилд шаардагдах 74.580.000 /Далан дөрвөн сая таван зуун наян мянга/ төгрөгийг ногоон байгууламжийн арчилгааны зардлаас санхүүжүүлэхийг Ахлах нягтлан бодогч /Б.Цэрмаа/-д зөвшөөрсүгэй.

УЛААНБААТАР ХОТЫН ЕРӨНХИЙ МЕНЕЖЕР
БӨГӨӨД ЗАХИРАГЧИЙН АЖЛЫН АЛБАНЫ
ЗДАРГА Ч.ГАНТӨМӨР

1110301008

Улаанбаатар хотын Ерөнхий менежерийн
2019 оны 10 дугаар сарын 18-ны өдрийн
А/329 тушаалын 1 дүгээр хавсралт

УЛААНБААТАР ХОТЫН НОГООН БАЙГУУЛАМЖИЙН НАМРЫН ТАРИЛТ, АРЧИЛГАА, ХАМГААЛАЛТЫН АЖЛЫН ХҮРЭЭНД ХИЙГДЭХ АЖЛЫН ЗАРДЛЫН ЗАДАРГАА

д/д	Байршил, ажлын нэр	Тоо хэмжээ /ширхэг/	Нэгжийн үнэ /төгрөг/	Зарцуулах хөрөнгө /сая.төг/
1	Хан-Уул дүүрэг, Баянгол дүүрэгт мод хэлбэржүүлэх	1500	23.600	23.600.000
2	Сүхбаатар дүүрэг, Баянзүрх дүүрэгт мод хэлбэржүүлэх	1500	23.600	23.600.000
3	Нийслэлийн ногоон байгууламжийн бүтээн байгуулалтын “Бургасны самар” номны захиалга	200	20.000	4.000.000
4	Жуулчны гудамжинд том мод тарьсан ажлын гүйцэтгэл	28	380.000	10.640.000
5	Самбуугийн гудамжны зүлэг тарьсан ажлын гүйцэтгэл	82м^2	15.853	1.300.000
6	Занабазарын гудамжинд улиас тарих ажил	22	20.000	440.000
7	“Бүх нийтийн мод тарих үндэсний өдөр” -өөр хотын төвийн зарим гудамж цэцэрлэгт гацуур тарих	15	200.000	3.000.000
8	Манай хороо-Миний гудамж аянд шалгарсан /орон сууц, гэр хороо тус бүр - 3, хог хаягдлын үйлчилгээний байгууллага - 2/ хороодод олгох мөнгөн урамшуулал	8	1.000.000	8.000.000
	ДҮН			**74.580.000**